# МОНГОЛ УЛСЫН ТУСГААР ТОГТНОЛД ЦАГДААГИЙН ГҮЙЦЭТГЭСЭН ҮҮРЭГ (1911-1915)

**М.Эрдэнэбаяр**
Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D), цагдаагийн хурандаа
**Ц.Минжин**
Хууль сахиулахын удирдлагын академийн АБУСПБ-ийн ахлах багш, доктор (Ph.D), цагдаагийн дэслэгч

**Товч агуулга:** Хүн төрөлхтний түүх бол их аян дайнууд, үндэстнүүдийн их хөдөлгөөн, нүүдэллэлт, ард түмнүүдийн зохицол, уусалт, ойлголцлын түүх бөгөөд үүнд монголчууд ч өөрсдийн үүргээ гүйцэтгэсэн юм.

Монголчууд түүхийн олон үеийг туулсан бөгөөд 1911 он түүхт цагаагчин гахай жилийн хувьсгалаас эхлэн орчин цагийн түүх эхэлдэг. Монголчууд тусгаар тогтнолоо сэргээн тунхагласан 1911 оноос Орос, Хятад, Монгол гурван улсын хэлэлцээр хийгдсэн 1915 он хүртэлх энэ зурвас үе бол Монголын цагдаагийн байгууллагын эх үүсвэр тавигдсан олон чухал үйл явдал холбогдохыг түүхэн баримтууд харуулдаг. ХСИС-ийн судлаачдын багийн “Монгол улсад орчин үеийн цагдаагийн байгууллага үүссэн он цаг, үечлэл” сэдэвт судалгааны ажлын тайлангийн хүрээнд энэхүү өгүүллээ бичиж байна. Үүнд:

1. 1911 оны түүхэн үйл явдал, нөхцөл байдал
2. 1911-1915 оны цагдаагийн үйл ажиллагаа, гүйцэтгэсэн үүрэг гэсэн агуулгаар гаргах болсон нь “Цагдаа цэрэг” хэмээх алба бий болсон хийгээд тухайн үеийн нийгэмд чухам ямар үүрэг гүйцэтгэж, ямар үйл ажиллагаа явуулж байсныг баримтад тулгуурлан бичихийг зорьсон цуврал өгүүллийн анхных нь болно.

**Тулхуур** *үгс: Богд хаан, “Цагдаа цэрэг”, төр, гэмт хэрэг, үйл ажиллагаа, үүрэг*

## 1.1911 оны түүхэн үйл явдал, нөхцөл байдал

Монголчууд 100 гаруйхан жилийн өмнө буюу 1911 оны цагаагчин гахай жилийн хувьсгалаар тусгаар тогтнолоо зарлаж Монгол улсыг тунхагласаар бид Манжийн эрхшээлээс гарч дэлхий дахинд өөрсдийн дуу хоолойг хүргэхэд хичээн чармайсан он жилүүд үргэлжилсэн юм.

Монгол Улсын түүхэнд 200 гаруй жил үргэлжилсэн Манж Чин гүрний ноёрхлыг эцэс болгон Монгол төрийг сэргээн байгуулж, монголчуудын

сэргэн мандлын эхийг тавьсан 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгал нь төрт ёсны өнө эртний уламжлалтай монголын ард түмний түүхийн онцгой хуудас, хойч үе нь бахархан дурсвал зохих түүхт үйл явдал юм.

Үндэсний эрх чөлөөний хувьсгал нь монголчуудын тусгаар улсаа сэргээн байгуулах гэсэн олон арван жилийн мохошгүй хүсэл тэмүүлэл, тууштай тэмцлийн биелэл, үндэсний ухамсрын их сэргэлтийн эхлэл байсан юм.

XIX зууны эцэс гэхэд Манжийн төр ихэд суларч, энд тэндгүй бослого үймээн гарах болов. Солонгос Манжаас тусгаарлаж, Хятадад хөрөнгөтний хувьсгал гарч Орос орон далдуур дэмжих болсон нь Монголчуудын урмыг сэргээж Манжийн шинэ засгийн бодлогын хүрээн дэх ашигт малтмал олборлох, тариа тарих явдлыг эсэргүүцсэн бослого энд, тэндгүй гарав. Богд хаан тэргүүт Монгольш ноёд Оросоос тусламж эрэн Манжийн хүч суларсныг ашиглан Халхын хүрээний бүх хэргийг Түр ерөнхийлөн шийтгэх газар байгуулан Ханддорж, Чагдаржав, Цэрэнчимэд нар удирдах болов.

Тухайн үеийн монголчууд XIX зууны сүүлчээр Чин гүрний "Шинэ засгийн бодлого"-ыг Монголд хэрэгжүүлж эхэлсэн үеэс эсэргүүцэн, хэрэв энэ арга хэмжээ хэрэгжвэл **"Монголчуудын язгуурын ёс"** алдагдахад хүрнэ гэж үзэж байв.

Халхын эрх баригч ноёд, дээд лам нар 1911 оны 6 сарын 21 нд Живзундамба хутагтад бат оршил өргөх ялдамд их хүрээнд нууц зөвлөгөөн хийж, тус зөвлөгөөнд оролцогсод, Богдын "Чин улсын шинэ засгийн бодлогыг хүлээх эсэхийг эрс тэс санал гаргаж нэгтгэн мэдүүл" гэсэн лүндэн буулгасны хариуд Түшээт хан, Сэцэн хан, Засагт хан, Сайн ноён хан зэрэг томоохон ноёд Монголын тусгаар тогтнолын төлөө тууштай байр суурьтай зарим түшмэл лам нар олонх болж, Чин улс гүнзгий хямралтай байгаа үеийг ашиглан Монголчууд төрийн тусгаар тогтнолоо сэргээхийн төлөө шийдэмгий шаргуу тэмцэх нь чухал гэсэн шийдвэр гаргасан байна.

Их хүрээн дэх ноёд лам нар хэрхэх тухайгаа хэлэлцээд, төрийн тусгаар тогтнолыг сэргээх хэргийг шууд удирдан эрхлэх байгууллага- "Халхын хүрээний бүх хэргийг түр ерөнхийлөн шийтгэх газар" /ХХБХТЕШГ/ гэгчийг Түшээт хан аймгийн чуулган дарга Чагдаржаваар толгойлуулан 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр 1911 оны 11 дүгээр сарын 30-нд байгуулав.

Түр ерөнхийлөн шийтгэх газрын ойрын зорилго нь:

- Монголын тусгаар тогтнолыг зарлан тунхаглах,
- Манж, Хятад цэргийг Монголын хязгаараас хөөн гаргах,
- Шинэ төрийн байгууллагуудыг үүсгэн байгуулах алхмуудыг яаравчлан хийх явдал байв.

Эдгээр зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд ерөнхийлөн шийтгэх газраас хувьсгалын ялалтыг хангаж дараах арга хэмжээг авчээ.

Үүнд: Живзундамба хутагтын лүндэнг Ар, Өвөр Монголын засаг ноёд Барга, Алаша. Хөх нуур, Ил Тарвагатайн монголчуудад яаралтай дамжуулахдаа Живзундамба хутаггыг Монгол улсын хаанд өргөмжлөн, шашин төрийн бүх хэргийг түүний гарт төвлөрүүлэхийг мэдэгдсэн байна.

Монголын төрийг сэргээн мандуулах тунхгийг 1911 оны 12 дугаар сарын 1-нд гарган Монголчууд тусгаар улс болох бүрэн эрхтэй бөгөөд зөвхөн Манж. Хятад эрх баригчдын эсрэг тэмцэж байгаагаа олон түмнээ зарлан тунхаг гаргаж, гудамж, зах зээлийн газраар нааж зарласан байна. “Түр засгийн газар байгуулагдсан цагаасаа эхлэн Манж улсын хэвт ёсыг халж, ...12 сарын 10-ны үеэр манжийн цагдаа, өртөө, харуулыг татан буулгасныг мэдэгджээ."[86]

12 дугаар сарын 12-нд Халхын 4 аймаг, Хиагтын харуулын газар, мөн сарын 17-нд Шилийн гол, Улаан цав, Их зуугийн чуулганы дарга нар, Алаша ван, Дарьганга, Шинэ хуучин баргын олон хошуу, бүгдийн дарга нарт илч довтолгон өөр өөрийн хошууны нутгийн сүв боомт газар цэрэг яаралтай томилон суулгаж, нутаг орныг ариутгахыг даалгажээ.

Түр засгийн газраас давын өмнө хэрэгжүүлсэн ажил бол хүрээнээс амбан сайдыг хөөж, Монголын тусгаар тогтнолыг тунхаглан зарлах, улсын сан бүрдүүлэх, хил хязгаарыг цагдан сэргийлэх, тусгаар тогтнолын илэрхийлэл болсон улсын эзэн хааныг өргөмжлөх, төрийн таван яамыг байгуулах зэрэг олон чухал ажлыг гүйцэтгэсэн. Эдгээр ажил дотроо “цагдаа” хэмээх цэрэг байх ёстойг ч огт орхигдуулаагүй байна.

Энэхүү 1911 оны үндэсний хувьсгал өөрөө амжилтад хүрсэн нэг гол учир шалтгаан нь бүх монгол овогтон үндэсний үзлээрээ нэгдэж, нэгдмэл нэг зорилгын төлөө бурхны шашныхаа тэргүүнийг хүрээлж, түүхэн амжилтад хүрсэн билээ.

Монгол Манж гүрнээс салж тусгаар тогтнолоо зарласны дараа Богд Живзундамба Агваанлувсанчойжинямданзанванчүг (1869-1924)-ийг Монголын эзэн хаанаар өргөмжилсөн өдрөөс хойш 1924 оны 5 дугаар сарын 20 хүртэл Монгол төрийн тамгыг атгасан сүүлчийн хаан байсан юм.

Богд хаан энэ ёслолын дараа төрийн их хэргийг эрхлүүлэхээр Дотоод, Гадаад, Цэрэг, Сан, Шүүх гэсэн 5 яамыг байгуулж олон аймаг хошууны засаг захиргааг хуучин хэвээр явуулж тус тусын засаг ноёдын цол хэргэмийг хэвээр хэрэглүүлэн нийтээр нэгэн зэрэг дэвшүүлэн шагнажээ.

Монголд шинэ тулгар тогтсон төр нь хэлбэрийн хувьд шашин-төрийг хослон барьсан хажлагат ёсны хэмжээгүй эрхт хаант төр байв. Төрийн уламжлалт үзэл баримтлал, нөгөө талаас Богд гэгээн өөрөө сүсэгтэн олны

[86] Батсайхан О. “Монголын сүүлчийн эзэн хаан VIII Богд Жавзандамба”. УБ., 2014. т.76

дунд "амьд бурхан" хэмээн шүтэгдэж байсан тухайн үеийн давуу байдал нөлөөлжээ.

Олноо Өргөгдсөн Монгол улсын яам нь 5 яамдаас бүрдэж байв. Үүнд:

1.Гадаад хэргийг эрхлэн шийтгэх яам Чин ван Ханддорж/Одоогийн гадаад хэргийн яам/,

2 .Цэргийн яам Эрдэнэ далай ван Гомбосүрэн/Одоогийн батлан хамгаалах яам/,

3 .Сангийн яам Түшээ гүнЧагдаржав/ Одоогийн сангийн яам/,

4 .Шүүх яам Эрдэнэ ван Намсрай,

5 .Дотоод явдлын яам Да лам Цэрэнчимэд /Одоогийн хууль зүй, дотоод хэргийн яам/ нарын сайдтайгаар байгуулагдав.

Эдгээр сайд нарын эрх мэдлийн зөрчилдөөний улмаас тэдний дээр ерөнхий сайдаар Сайн Ноён хан Намнансүрэнг тавьжээ.

Үндэсний Эрх Чөлөөний Хувьсгалын үр дүнд 1911 онд гарсан улс төрийн энэ эргэлт нь Засгийн эрхийг Монголчуудад өөрт нь шилжүүлж, үндэсний тусгаар тогтнолын төлөө тэмцэлд Чин улсын захиргаанд байсан монгол угсаатнууд төдийгүй, Орос улсын бүрэлдэхүүнд байсан торгууд, буриадын эх оронч төлөөлөгч монгол угсаатныг татан оролцуулсан нь монголын түүхэн эгзэгтэй үеийн томоохон үйл явдлын нэг юм. Уг хувьсгалд нийгмийн бүх анги давхаргыг хамарч, хувьсгалын удирдагчид нь Монголын ноёд язгууртнууд байсан.

Монголчуудын Үндэсний Эрх Чөлөөний тэмцлийн гараag хязгаарлагдмал дэмжсэн Орос улс, Дундад иргэн улстай хуйвалдан, өөр өөрсдийн эрх ашгийн үүднээс Монголын тусгаар тогтнолыг цуцалж, зөвхөн Ар монголыг Дундад Иргэн Улсын харьяанд автономит эрхтэй байлгах 1915 оны Хаигтын гэрээг байгуулснаар Монголын цагаагчин гахай жилийн хувьсгалын гол үр дүнг бууруулсан юм.

**2. 1911-1915 оны "Цагдаа цэрэг"-ийн үйл ажиллагаа, гүйцэтгэсэн үүрэг**

Монгол улс тусгаар тогтоолоо тунхагласан 1911 онд 5 яам байгуулсны нэг нь цэргийн яам байв. Тэр үеийн Монголын цэрэг нь төвийн буюу Нийслэл Хүрээг сахин хамгаалах цэрэг, хил хязгаарт суулгасан цэрэг, орон нутагт бэлтгэсэн цэргээс бүрдэж байв.

Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яаманд: цэргийн засгийг явуулах, цэрэг тэгшлэх, зэрэг дэв хянан байцаах гурван хэлтэс байгуулжээ. ...Цэрэг тэгшлэх хэлтэст дотоодыг хамгаалж, сэргийлэх, цагдан байцаах, Нийслэл Хүрээг манаж цагдуулах, цэргийн зэвсгийг байцаах, түшмэл цэргийг халах.

нөхөх, сурган боловсруулах, шалган үзүүлэх зэргийн хэргийг эрхлэн гүйцэтгүүлжээ.




Цэргийн бүтэц. зохион байгуулалтын хувьд Монголын цэрэг нь төвийн буюу Нийслэл Хүрээг сахин хамгаалах цэрэг, хил хязгаарт суулгасан цэрэг, орон нутагт бэлтгэсэн цэргээс бүрдэж байсны дотор "Цагдаа цэрэг" байгуулжээ.

Манжийн үеийн харгис цагдаа цэрэг, Богд хаантын үеийн цагдаа цэргээр солигдож, тэдний тоо нэлээд нэмэгджээ. Хүрээний ард түмний үймээн самуун газар сайгүй болж, төр засгийн бодлогыг хэрэгжүүлэх тулд Цагдан сэргийлэх газрыг Цэргийн яамны харьяанд байгуулжээ. Хүрээний Цагдан сэргийлэх газрын дарга нь Түмэнбаяр гүн гэгч орос хүнээр удирдуулсан шар хамжаарт морьт цагдаа цэрэг дөчин хоёр, захирах түшмэд дөрөв, улаан хамжаарт цагдаа цэрэг дөчин хоёр, захирах түшмэд нэг, мөн гадуур дотуур цагдах түшмэд дарга арван хоёр хүмүүн энэ албыг хашиж байв.

Энэ үеийн цагдаагийн түүхээр судлаач С.Бадарчи судалгаа хийн олон зүйлийг тодруулсны нэг нь Олноо өргөгдсөн Монгол улсын цагдаагийн зохион байгуулалт[87] юм.

Энэ үеийн "Цагдаа цэрэг"-ийн баримталж байсан хэм хэмжээ тогтоосон эрх зүйн акт бол "Богдын лүндэн" хэмээн хааны зарлиг байв.

Монгол цэргийн түүхэнд Хужир булангийн цэргийн ангийг байгуулснаар тусгай бэлтгэгдсэн цэрэг, цагдаагийн бие бүрэлдэхүүн бий болсон юм.

1911 онд Монгол Улсад Цагдаагийн алба нь цэргийн яаманд харьяалагдаж морьт ангийн цагдаа цэргийн Захирал нь Сэцэн хан аймгийн

[87] Бадарчи С. "Олноо өргөгдсөн Монгол Улсын цагдаа". УБ.. 2011. т. 34

Эрдэнэ гүн Дугарсүрэнгийн хошууны Нарандоной, явган цагдаа цэргийн дарга нь Түшээт хан аймгийн сайд, Дархан чин ван Пунцагцэрэнгийн хошууны Бунбаа нарын зэрэг орон нутгаас ирсэн хүмүүс ажиллаж байжээ.

Тухайн үеийн явган цэргийн байгуулагдсан учрыг явган цэргийн захирагч байсан Зайсан Цолмон илтгэлдээ:

"Цолмон миний тушаал болбоос гагцхүү улсын ханжаарт явган цэргийг захирах бөгөөд анх байгуулагдсан учир болбоос Шавиас занги1, цэрэг 14,Түшээт хан аймгаас занги 1, цэрэг 13, Сэцэн хан аймгаас захирах занги 1, занги 2, явган цэрэг 13, эдгээр 45 цэрэг өдөр, шөнө ямар нэгэн цагт Зээл ба Хороо харчууд, Баруун зүүн этгээдийн иргэдэд хулуух, булаах, хэрүүл шуугиан, хэрэг төвөг өдүүлэхийг цагдан сэргийлэхийн дээр, Усан хөөргөний хороонд өдөр, шөнө хорин хүн үргэлжид сахин сууж, гал бадрах хэрэг тохиолдвоос усны хөөрөг, хэрэгслийг авч одоод сөнөөнө"[88] хэмээн 1911 онд бичсэнээс харахад аймаг бүр нийслэлд өөр өөрийн харьяат ардаас занги болон цэргийг харилцан адилгүй тоогоор гарган өгч, өдөр, шөнө ээлжлэн үүрэг гүйцэтгүүлж байжээ.

1911-1915 он хүртэлх "Цагдаа цэрэг"-ийн гүйцэтгэж байсан үүргийг нотлох зарим архивын баримтаас дурдвал:

-Богд хааны 1912.02.09-ний "Шинэлэх өдрийн ёслолыг энэ удаа яаравчилж бүдүүвчлэн тогтоосон явдлыг айлтгасан айлтгал, хариу зарлиг"[89]

-"Аливаа Монголчууд орос нар Богд хаан хайрхан, Чингэлт хоёр ууланд жимс түүж зугаацан явахыг хориглон зогсоох явдлыг мөнхүү уулын цагдаа зангийн зэрэг найман газар явуулан тушаах бичиг" Олноо өргөгдсөний гуравдугаар он таван сарын арван долоон. /1913.07.16/[90]

[88] *МУҮТА, до.А-3, - ХН-457,*

[89] Нэгэн зүйл. Цагдаа цэргийг захирагч түшмэл хоёр харьяат дарга цэргүүдийг авч анги хувааж дотогш гадагш залрахын үест улаан шөргөний дотор сул хүн дэмий сэлгүүцэн явуулахгүй болго. Залрах тухайд харьяат түшмэд замын хоёр хажууд цэргийг жагсааж сөгтгө.

... Нэгэн зүйл. Цагдаа цэргийг захирагч хоёр түшмэл баруун, зүүн анги хувааж, жагсаалын дотор сул хүн явуулахгүй болго. Залрахуйд жагсааж сөгд, заларсны хойно эгүүл. т.3О *(ҮТА, Х-А3, Д-1, ХН-3, Хуу-92а-102а)*

[90] Богд хаан хайрхан уулын цагдаагийн занги Дэндэв нарт өргөн тушаан илгээв тушаав. ...цагдаагийн хүнд итгэмжилэн үнэмлүүлэх ажаамуу хэмээн илгээсэн бичгийг мөнхүү бичиг эрхлэх түшмэл биеэр авчирч хэлсэн үг. ...Эрхэм ууланд гөрөөс агнах, мод огтлох, газар ухах зэрэг хэрэгт огт гарахгүй хэмээснийг манай яамнаас мөнхүү түшмэлд энэхүү хоёр ууланд тийнхүү зугаацахаар явж үл болох цагдаа бүхүй учрыг хэлвээс мөн түшмэлээс энэ хоёр ууланд гарч үл болох цагдаа бүхүйг мэдмой гэтэл манай орос хүн нар жимс түүхээр зугаацан явмой. Цагдаа нар үзсэн мэдсэн атал огт хориглохгүй явуулах болсныг түшмэл би нийлэлцэхгүй хэмээхийг мэдээд болох эсэхийг танай яамнаас ийнхүү лавлан мэдүүлсэн хэрэг. Одоо танай яам харьяат цагдаагийн хүн нарт дахин тушааж зугаацан явах хүнийг хориглон зогсоолгохоос гадна. ...Богд хаан хайрхан уулын цагдаагийн занги Дэндэвт чангалан ухуулан тушаагаад бичгийн доторхыг хянан үзэж аливаа зугаацахаар явах орос, монгол хүн нарт учрыг сайхнаар ухуулан хэлж хориглон зогсоож хэрхэн зогсоосон учрыг манай яаманд мэдүүлэн ирүүлсүгэй. ... Олнаа өргөгдсөний гуравдугаар он зургаан сарын арван гурван. т. 237-238 *(МУҮТА, Х4-3, Д-1, ХН-448, /3-р нугалбар/)*

- “Цагдаа цэрэг"-т хүнсний хангалт олгох тухай.[91]

  *Орос хуурамч цаас* худалдаалахаар явж танигдсан хэргийн тухай ,..[92]
- Цаазалсныг зөрчиж зоос наадсан...[93]
- Хүн зодсон тухай[94]
- Гэмт хэрэг үйлдсэн гадаадын иргэнийг улсад нь шилжүүлэх.[95]
- Танхайрах, гадаад хүнийг харьяалах консулд хүргүүлэх[96]
- Цагдаа цэрэгт цалин олгох тухай[97]
- Цагдаа цэргийг захирах албанд сайнаар хүчин зүтгэсэн хүмүүсийг Богд хааны зарлигаар урамшуулан шагнах, тусгай дүрэмт хувцас өмсөх тухай ЦХБЗШЯамнаас СХБЗШЯ-нд 1913 оны 10 сарын 19-нд илгээсэн бичиг[98]

[91] Олноо өргөгдсөний 2-р он (1912), Өвлийн дундад сарын 10-ны бичигт дурьдсанаар нийслэл Хүрээний өмнө хойт хоёр замын утсыг (Телефон С.Б.) харгалзах *цагдаа цэрэг,* дарга хоёрын хөлсөнд тус бүр 9 хуудас мөн цагдаа цэрэг гурвын тус бүр зургаан хуудас, хятад нарыг буцахын янар, үүд хаалгыг харгалзан цагдахаар Хүрээнээс гаргасан цагдаа цэрэг албаны дөрвөн хүмүүний 10 хоногийн хүнсэнд 13 цаас, 90 мөнгө тус тус талбин олгосугай. (МУҮТА. хөмрөг А-4, д-1, х/н 16.)

[92] Олноо өргөгдсөний 2 дугаар он. хоёр сарын шинийн найманд ...Хүрээний газраа *Орос хуурамч цаас* худалдаалахаар явж танигдсан хэргийн ...нэг бүр тавын цаас хоёрыг мөн Отогийн Ялбагт нутагтай лам Дугарсүрэнгээс албаны оногдолд авсан. ...тэрхүү хуурамч цаасыг чухам ямар хүнээс авсан, хэрэв орос хүнээс авсан хэмээн аваас, хэн нэртэй оросоос хэдүйд авсан зэргийг түүгээр нягтлан байцаан тодорхойлуулж, хурданаа манай яамнаа мэдүүлэн ирүүлээд, ...уг хуурамч цаасыг *цагдаа* Балдандоржид тушааж хүргүүлсэн...(МУ ҮТА. Хөмрөг А-4, д/н, х/н 2, т.28.)

[93] Олноо өргөгдсөний хоёрдугаар он, цагаан сарын 29. Нийслэл хүрээний маймаа хотын иргэдийн хэргийг түр хамааран шийтгэх Луванцэрэн нарын бичиг: Цагаан сарын шинийн 13-ны өдөр: Цаазалсаныг зөрчиж зоос наадсан Хятад пүүсний иргэдийг Маймаа хотын Монгол цэрэг албаны хүмүүн нар тус тус барьж хүргэн ирсэнийг худалдааны дарга нарын хамт байцаан асууж Сай Цин Юн хэмээх пүүсийн иргэн Ли Сай Жу. Ран Миу нар буруугаа хүлээн мэдүүлсэнд... ( МУҮТА. Хөмрөг А-3, данс-1, х/н-349. т.3О.)

[94] ...(1912) 4-р сарын 23-нд Их шавийн харъяат хиа Найдангийн эхнэр Лянхуаг занчиж, дээл хувцасыг нь урсан ба цаас мөнгийг алдагдуулахад хүргүүлсэн Баруун дамнуургачины гурван гудамжинд суух мөнгөний дархан Намсрайн пүүсэнд баригдсан иргэн хүн нэгийг *цагдаа нарт* тушааж авахуулан харъяат түшмэл Лувсанцэрэн нарт хүргүүлсэн (МУҮТА. хөмрөг А-4, д-1, х/н 2. т.70)

[95] Гадаад яамнаас Дотоодын зэрэг дөрвөн яамнаас зөвлөн явуулах учир гэсэн нэгэн бичигт, энэ оны гурван сард манай газраас Нийслэл Хүрээний зэрэг газарт бусдын эд юмыг булаасан ...жич, хэв сахихгүй ямагт хэрэг будлиан өдүүлэн явж, удаа дараа баригдан сахиулсан ялт иргэн Ян Хэн Тин-ийн зэрэг таван хүмүүнийг уул улсад дамжуулан хүргүүлж, гүйцэтгэн шийтгүүлж, чангалан баримтлан захируулах учир дагах бичгийн хамт *цагдаа занги цэргүүдэд* тушааж зам тохиолдох Шилийн голын Чуулганы газар хүргүүлжээ. (МУҮТА. хөмрөг А-4, д-1, х/н 3. т.41 )

[96] Олноо өргөгдсөний 2-р он, Намрын тэргүүн сарын 25-ны бичигт: *Цэргийн яамны байшинд энэ 17-ны нар хэвийсэн цагт нэгэн халамцсан хүмүүн гүйн орж ирсний дараагаар монгол хэл үл мэдэх орос цэрэг 3 хүн буу сэлэм барьж ирэн тэр хүнийг чирэн өдөөхөд ...орос цэргүүд монгол хэл мэдэхгүйн дээр дүрсгүй авирлан, завдал үгүй чирж ноцолдон, яамны газрын бэлтгэл шаазан аягыг хэмхлэх зэргээр догшин загнахад ...тэр монгол хүн дахин зугтан гарч, мөн орос цэрэг сэлэм, буу барьж нэхэхээр одоход, яаран* ***цагдаагийн*** *зэрэг албаны хүмүүсийг гаргаж, хойноос нь нэхүүлэн ...бариулсан боловч, орос цэрэг учир ухаж хүлээхгүй хэвээр догшин авирлахад хэрэг гарахаас болгоомжлон цагдаагийн занги Нарандоогийн зэрэг дөрвөн хүнийг гаргаж, дагалдуулан харгалзуулж, Консулын яамны гадаа хүргүүлэв* гэжээ. (МУҮТА. хөмрөг А-4, д-1, х/н 1. т.74-75)

[97] Тэрчилэн дөрвөн аймгаас Нийслэл Хүрээнд суулгасан цэрэг (цагдаа) ба захирах түшмэл, бичээч, эмч, хөтөч нарт олгож байсан цалингийн хүснэгтүүд хадгалагдан үлджээ. Цэрэг цагдаа нар 9 лан, захирагч 15 лан. эмч 18 лан, хөтөч 9 лан мөнгөний цалинтай байжээ.(МУҮТА. Ф. А-5, д-1, х/н 21. )

[98] *...Нийслэл Хүрээг цагдан байцаах цагдаа цэргүүдийг захирах* түшээт сайн хан Доржсүрэнгүлжавын хошууны дөтгөөр зэрэг Наваанчимбыг зэрэг дэвшүүлэх ба харъяат даргуудын хүрэмд Монгол улсын Нийслэл Хүрээг хамгаалан байцаах морьт ангийн цагдаа цэргийг захирах дарга; Цагдаа цэргүүдийн ханжаарт *Монгол улсын Нийслэл Хүрээг хамгаалан байцаах морьт ангийн цагдаа цэрэг* хэмээх үсэг тус

-“Бүгд ерөнхийлөн захирах яамнаас харьяат олон яамны эрхлэн шийтгэх хэрэг зүйлийг ялган салгаж айлтгаад Зарлиг ёсоор болгосныг хичээнгүйлэн болгосныг хичээнгүйлэн дагаж шийтгүүлэхээр ирсэн хэрэг” 1913.08.28"

- “Зах зээлийг цагдан байцаах цагдаа цэрэг нарын түлш зэргийг харьяат уул ноосон аймаг хошуудаас тэгшлэн гаргуулж дагнуулах учрыг зохих газраа явуулан тушаагаад мэдэгдэн ирсэн хэрэг” 1914.05.31 [100]

Дээрх зарлиг болоод баримт бусад сурвалжийн агуулгыг нэгтгэвэл Монгол улсын тусгаар тогтнолд цагдаа нар биечлэн ямар үүрэг гүйцэтгэсэн тухайд тодруулж болох юм. Тухайлбал:

- Түүхийн ээдрээтэй энэ цаг үед төрийн албан бичиг хэрэг болоод тамгыг цагдаа нар өөрийн биеэр хүлээлгэн өгч байсан нь Монгол төр төдийлөн бэхжиж чадаагүй энэ үеийн чухал хариуцлагатай ажил байв. Энэ үүргийг архивын баримтад тулгуурлан “цагдаа Лувсангомбо 5, удаа Шанж 2,Сандаг, Гэндэн, Санжаа нар болон өөр нэгжид цагдаа Хайдав, Алтангэрэл, Дугаржав, Баяр, Хандсүрэн, Авирмэд нар тус бүр нэг удаа бичиг хүргэсэн”[101] гэжээ.

  Богд хаан, Дондогдулам хатны ордон өргөө, төрийн яамд болон цахилгаан утасны хороо зэрэг чухал газруудыг төрийн хамгаалалтад авч төрийн үйл хэрэг саадгүй явах үндсэн нөхцөлийг бүрдүүлж байв. Түүнчлэн төрийн аливаа ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаанд төрийн дэгийн дагуу сул иргэдийг журамлах хийгээд хамгаалалтын бүс гортиг татан аюулгүй ажиллагааг хангаж байв.
- Цагдаа цэргийг захирагч, түшмэл хоёр харьяат дарга цэргүүдийг авч анги хуваан захирдаг.

тус бичиж, хүрэм ханжаарыг ямар зүйлийн өнгө хэрэглэвээс болох явдлыг айлтгасанд дээд зарлиг буулгасан ану.

Цагдаагийн түшмэл цэргийг захирах Наваанчимбад дэд зэрэг, жинс шагнан хадуул.

Хүрэм ханжаарыг цөм цайвар шаравтар өнгө болго, дэвсгэрт бичих үсгийн өнгийг харъяат яамнаас хянан махбодын өнгө лугаа зохилдуулан бичигтун хэмээснийг хичээнгүйлэн дагаж, Нийслэл Хүрээний цагдаагийн түшмэл, цэргийг захирах дэд зэрэг түшмэл Наваанчимбад тушаагаад буулгасан.

Дээд зарлигийг хичээнгүйлэн дагаж тэнгэрийн хишигт мөргөхөөс гадна харъяат түшмэд, цагдаа цэргүүдийн тэмдэгт хүрэм, ханжаарыг цөм цайвар шаравтар өнгөөр үйлдүүлж, дараа манай яамнаас үсгийг сийлүүлэн, өнгийг тогтоож, дармал дарж тушаасан цагт мөрдөж явсугай. (МУ ҮТА. хөмрөг А-6, д-1, х/н 53. т.20)

[99] ...Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яамны эрхлэн шийтгэх хэргийг товчилвоос. ...цагдах, манах зэрэг хэргийг эрхлэн шийтгэмүй. ... Олнаа өргөгдсөний гуравдугаар он долоон сарын хорин долоонд хүргэн ирвэй. т. 241-242 *(МУҮТА, ХА-3, Д-1, ХН-413, /4-р нугалбар/)*

[100] ...Эдүгээ Нийслэл хүрээн дэх Засагт хан аймгийн жасаанаас өргөсөн бичигт өргөв мэдүүлэх учир эдүгээ зээл захыг цагдан байцаах орос гүн Түмэнбаяр цагдаа нарын суух газар түлэх модыг дөрвөн аймгаас цаг дараалан нийлүүлэхэд урт нь зургаан чий, бүдүүн нь таван цоны мод аймгийг тутам нижгээд зуу, бас голын ордоны газраа сууж албан хаах цагдаа нарт цаг бүрт нийлүүлэх халтар мод гуч, лаа гуч, дамар тогшуур тус бүр хоршоодыг нийлүүлэгтүн хэмээн гүн Түмэнбаяр цагдаа нар шаардахад... Олнаа өргөгдсөний дөрөвдүгээр он дөрвөн сарын шинийн зургаан. т. 309-312 *(МУҮТА, Х4-2, Д-1, ХН-210, /47-р нугалбар/)*

[101] Бадарчи С. “Олноо өргөгдсөн Монгол Улсын цагдаа”, УБ., 2011. т.40

Хаан болон өндөр дээд албан тушаалтан залрах үед замын хоёр хажууд хамгаалалт хийж. жагсаалын дотор сул хүн явуулахгүй, хаан залрахуйд жагсааж сөгддөг дэг тогтоодог.

Богд хаан ууланд цагдаагийн хамгаалалт, эргүүл гарган ажилладаг.

Зээл захыг цагдан байцаадаг.

- Хуурамч мөнгөн тэмдэг хийх, худалдах, мөрийтэй тоглохыг хориглодог.

Цагдаа нар дөрвөн аймгаас хангалт авдаг, хүнсний хангалтыг мөнгөөх тооцох, цалин пүнлүү ялгамжтай олгодог.

- Дүрэмт хувцас хэрэглэх, цол, жинсээр шагнах
- Хэрэг гарах, хулгай гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг.
- Гэмт хэрэгтэнг барьдаг, хэрэг хийсэн гадаадын иргэнийг шилжүүлэн өгдөг.

Хэм хэмжээ тогтоолгох тухайд өргөн мэдүүлэх гэх мэт өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа явуулж байжээ.

Судлаач С.Бадарчи судалгаандаа энэ үеийн “Цагдаа цэрэг”-ийн гүйцэтгэсэн үүргийг бичихдээ “1911-1916 он буюу Цагдан сэргийлэх хороо байгуулагдах хүртэл Богд хаант Монгол улсын цагдаа гэмт явдал, хэв журмын зөрчилтэй тэмцэх талаар үлэмжхэн ажлыг гүйцэтгэсэн юм.

• Хиагтад үхсэн Монгол хүний хүүрийг байцаан үзэж, үхлийн шалтгааныг тогтоолгон

• Газар дэлхийг сүйтгэж, рашаан усыг бохирдуулж, занга тавьж ан агнаж байгаа хэл мэдэхгүй Орос, хужаа нарыг цагдахын тулд Богд хан, Отгон хайрхан. Хан Хэнтий уулыг хамгаалах цагдаа нарын тоог нэмэгдүүлсэн

• Хулгай дээрэм хийсэн, хүний амины хэрэг үйлдсэн, цуурхал тараасан, хүчиндсэн, бусдын юмыг зүй бусаар ашигласан, зүй бус үг хэлсэн олон хүнийг илрүүлэн, баривчилж шийтгэл ногдуулсан

• Албан хэрэгт ноёдын цолыг буруу бичсэн, ташаарсан, тамга тэмдгийг буруу дарж будлиантуулсан, үг үсгийн алдаа гаргагчдыг сэргийлж илчилж торгосон

• Монгол хүүхнийг хятад нөхөрт богтлохыг оролдсон хэргийг илрүүлсэн

• Харуул манааны хариуцлагыг дээшлүүлж, галын аюулаас сэргийлсэн

• Өвөр Монголоос дагаар ирсэн, дайсны цэрэгт хэлмэгдсэн хүмүүст тэтгэлэг олгуулсан

• Нийслэл Хүрээ, Маймаа хот, Харчууд, Шавь отогт суугаа хүн амын тоог гаргуулсан

• Аливаа хүн мөрийцөж морь уралдах, архи уух, даалуу хөзрөөр мөрийцөх, золиг монди гэж хараал хэлэх явдлыг нийгмийн хэв ёсыг зөрчсөн хэрэг гэж үзэж үүрд сэргийлүүлсэн”[102] хэмээн үйл ажиллагааг нь нэгтгэн дүгнэсэн агуулгаар нь бид цаашдын судалгаандаа улам дэлгэрүүлэн баримтуудыг нэмж баяжуулан цагдаагийн гүйцэтгэсэн үүрэг, үйл ажиллагааны хүрээний зураглал хийж болох юм.

Энэ үеийн цагдаагийн эргүүлийн талаар тухайн үед Монгол ирж байсан Оросын эрдэмтэн Майский: *"Монголй байгаа маймаачин газар сайгүй л өөрийн цагдаагийн онцгой газартай, цагдаагийн онцгой манаатай... байх ажээ. Хятадын эргүүлүүд шөнийн цагаар хоёр цаг тутамд гудамж эргэж дэг журам, нийгмийн аюулгүй байдлыг хянана. Ингэж явах бүрийд гуулин харанга нэг удаа дэлдэнэ. Эхний эргүүл хийхэд нэг дэлдэнэ, хоёр Оахь эргүүл хийхэд хоёр удаа дэлдэнэ, гэх мэтээр таван удаа эргэхэд таван удаа дэлдэнэ. Цагдаагийн шөнийн эргүүлийн харангын дохиог хятад монголгүй анддаггүй. Тэд түүнийг “чжин ” гэж нэрлэдэг. Энэ харанга дэлдэх нь цагдаагийн шууд үүргээс гадна бас цаг хэд болж буйг мэдээлэх үүрэгтэй байгаа нь манай оросын манаачийн шовгорын дохиотой төстэй юм ”*[103] гэж бичиж байснаас үзэхэд Монгол цагдаа цэргийн үйл ажиллагаа зарим талаараа Оросын цагдаагийн үйл ажиллагаатай ижил төсөө бүхий үйл ажиллагаа явуулж байсныг ч харьцуулан судлах боломжтой юм.

Эцэст нь дүгнэж хэлэхэд 1911-1915 оны Монголын төр, шашны харилцаа нь өргөн хүрээтэй, олон талт, агуулга өргөн, ач холбогдол гүн харилцаа байсныг тэмдэглэх хэрэгтэй. Судлаач Г.Мягмарсамбуу ‘Тэвч шашин төрийн харилцаа “хос ёс” -ны тухай ойлголтыг зөвхөн нэг хүний гарт шашин, төрийн эрх мэдэл бүрэн төвлөрч байсан төдийгөөр тайлбарлах нь учир дутагдалтай. Зүй нь шашин төрийн харилцааны агуулга, мөн чанарыг бүрэн гүйцэд гаргахын тулд уг асуудлыг нийгмийн системийнх нь хүрээнд цогц байдлаар авч үзэх шаардлагатай байна. Гэвч энэ бол багагүй цаг хугацаа, хүч хөдөлмөр шаардах судалгаа болно”[104] гэж бичсэнийг бид дэмжиж байгаа бөгөөд Цагдаагийн байгууллагын системийн хүрээнд өргөн судалгаа хийх бидний эхлэл энэ мэт болой.

Цагаагчин гахай жил 1911 онд Монгол төрийн 5 яам байгуулахтай зэрэгцэн Цэргийн яамны бүрэлдэхүүнд “Цагдаа цэрэг” буюу "Монгол цагдаа”-гийн бие бүрэлдэхүүн үүсэж, үйл ажиллагаагаа явуулж ирсэн нь Манжийн үеийн “Харгис цагдаа”-аас үйл ажиллагаа хийгээд, зорьж буй зорилгын хувьд үндсээрээ өөр байсан юм. Энэ үеийн “Цагдаа цэрэг”-ийн бүрэлдэхүүнийг дөрвөн аймгаас дарга болон цэргийн хамт Их хүрээнд татан

[102] Бадарчи С. "Олноо өргөгдсөн Монгол Улсын цагдаа”, УБ.. 2011. т.37

[103] Майский И. Орчин үеийн Монгол (Автономит Монгол XX зууны гараан дээр). Орч. Ц.Отхон. УБ.. 2001.Т. 91

[104] Мягмарсамбуу Г. " Богдхааны тоггоосон шашин төрийн ёс” УБ..2015.Т.4-5

авчирч Хүрээний Түшээт. Сэцэн хоёр аймгийн Чуулганы дарга, жанжид, Засагт. Сайн ноён хоёр аймгийн суурин Жасаадад болон Эрдэнэ Шанзудбын яамнаа захирдаг байв.

"Цагдаа цэрэг" нь тухайн нийгмийн ороо бусгай, гадаад дотоодын үймээн самуун ихтэй цаг үед төрийн үйл ажиллагааг хэвийн явуулахад хамгаалалт хийх. гэмт хэрэг. хэв журмын зөрчил гарахаас цаггүй цагдан сэргийлэх. хүрээнд буй Орос, Хятад, Түвэд, Америк, Герман зэрэг олон улсын элч. төлөөлөгч, худалдаачид хийгээд бусад энгийн иргэдийн амгалан тайван байдлыг сахиулж байлаа.

Энэ үед шинээр зохион байгуулагдсан "Цагдаа цэрэг" нь нийгмийн мөн чанараас үл хамааран төрийн бодлогын хэрэгжүүлэхэд хүчтэй дэмжлэг үзүүлэхээс гадна хүн амын аюулгүй байдлыг хамгаалах энэрэнгүй, ариун үйлсийн төлөө зогсох үйл хэргээ амжилттай гүйцэтгэсэн юм.

Үндэсний хувьсгал ялсан 1911 онд Монголын ард түмэн Манжийн ноёрхлоос ангижирч, тусгаар улсыг байгуулсан ч гэсэн нийгэм бүрэн тогтворжоогүй, нийслэл хүрээ хийгээд орон нутагт элдэв хэрэг зөрчил гарч, Монгол төрийн эсрэг олон гэмт хэрэг хийгээд үйл явдлууд өрнөсөөр байсан тэр цаг хугцаанд гэмт хэргээс урьдчилан сэргийлж, гэмт хэрэгтэнг эрэн сурвалжилж, баривчилж, Монгол төрийн өмнөөс ял зэмлэл оногдуулахад нь "Цагдаа цэрэг" ихээхэн үнэтэй бөгөөд чухал үүрэг гүйцэтгэсэн гэдгийг архивын олон баримт гэрчлэн үлдээж байна.

1911-1915 он хүртэл Цэргийн яаны харъянд ажилласан "Цагдаа цэрэг"-ийг үйл ажиллагаа 1916 онд Цагдан сэргийлэх албаны газрыг байгуулж, үйл ажиллагаанд эрх зүйн үндсийг батлан мөрдүүлсэн явдлаар өөрийн халаагаа өгч Монгол цагдаагийн түүхэнд өмнө нь байгаагүй түүхийн шинэ хуудсыг нээж, шинэ тутам байгуулагдсан төрийн үйл ажиллагааг бататган бэхжүүлэхэд Дотоодын цэргийн хамтаар томоохон үүрэг гүйцэтгэсэн болохын дараа дараачийн өгүүлэлдээ танилцуулах болно.

**Эх сурвалжийн жагсаалт**


1. Бадарчи С. "Олноо өргөгдсөн Монгол Улсын цагдаа", УБ., 2011.
2. Батсайхан О. "Монголын сүүлчийн эзэн хаан VIII Богд Жавзандамба". УБ., 2014.
3. Майский И. Орчин үеийн Монгол (Автономит Монгол XX зууны гараан дээр). Орч. Ц.Отхон. УБ., 2001.
4. Мягмарсамбуу Г. " Богд хааны тогтоосон шашин төрийн ёс" УБ.,2015.
5. *МҮҮТА, до.А-3, -ХН-457,*
6. *МҮҮТА, ХА-2, Д-1, ХН-210, /47-р нугалбар/*
7. МҮҮТА *Х-А3, Д-1, ХН-3, Хуу-92а-102а*

8. *МУҮТА, ХА-3, Д-1, ХН-413, /4-р иугалбар/*
9. *МУҮТА, ХА-3, Д-1, ХН-448, /3-р нугалбар/*
10. МУҮТА. Ф. А-5, д-1, х/н 21.
11. МУҮТА. Хөмрөг А-3, данс-1, х/н-349. т.30.
12. МУҮТА. Хөмрөг А-4, д/н, х/н 2, т.28.
13. МУҮТА. хөмрөг А-4, д-1, х/н 1. т.74-75
14. МУҮТА. хөмрөг А-4, д-1, х/н 16.
15. МУҮТА. хөмрөг А-4, д-1, х/н 2. т.70
16. МУҮТА. хөмрөг А-4, д-1, х/н 3. т.41
17. МУҮТА. хөмрөг А-6, д-1, х/н 53. т.20